



**МОНГОЛЫН  
ЦАХИЛГААН  
ХОЛБОО ХК**

# **ЖИЛИЙН ТАЙЛАН** 2021



## КОМПАНИЙН ТУХАЙ

Монголын цахилгаан холбоо ХК нь 1921 онд “Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо” нэрээр эмхлэгдэн байгуулагдсан, 100 жилийн түүхтэй, Монгол Улсын харилцаа холбооны салбарын ууган компани юм.

Компани нь 1992 онд “Монголын Харилцаа Холбоо” (МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО) компани, 1995 онд “Монголын Цахилгаан Холбоо” хувьцаат компани болон байгуулагдаж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж байсан, Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани юм.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 54.67 хувийг Монгол улсын Засгийн газар, 40.0 хувийг БНСУ-ын Кореа Телеком корпораци, 5.33 хувийг Монгол улсын болон гадаадын иргэд, хуулийн этгээд тус тус 1995 оноос 2018 оны хооронд эзэмшиж байсан.

Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Кореа телеком корпораци хооронд 2018 оны 4 сарын 19-ний өдөр байгуулсан гэрээний дагуу компанийн нийт хувьцааны 40 хувь буюу 10,348,111 ширхэг хувьцааг худалдах арилжаагаар Монгол Улсын Засгийн Газар Монголын цахилгаан холбоо ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа худалдан авсан.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.

Монголын цахилгаан холбоо ХК нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт улс, хот хоорондын цахилгаан холбоо, интернэт, кабелийн телевиз, лавлах үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж ажилладаг.

Монголын цахилгаан холбоо ХК нь Улаанбаатар хотын бүх дүүрэг, 21 аймаг, 290 гаруй сум сууринд үйлчилгээгээ хүргэн ажиллаж байгаа бөгөөд нийт 695 ажилтан, албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Алсын хараа

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн өргөн сонголт бүхий үйлчилгээ үзүүлэгч, өрсөлдөх чадвараар салбартаа тэргүүлэгч компани байна.

### **ЭРХЭМ ЗОРИЛГО**

Харилцаа бүрийг холбоно.

### **ҮНЭТ ЗҮЙЛС**

#### **Хэрэглэгчийн дээдлэл:**

- Бид хэрэглэгч бүрийг зочин мэт дээдэлнэ.
- Бидний бүх ажил ямагт хэрэглэгчийн төлөө байна.
- Бид хэрэглэгчээ танин мэдэж, хэрэгцээ шаардлагад нь өөриймсөг хандана.

#### **Хамт олон:**

- Бид бэрхшээл саадыг хамтдаа туулж, амжилт ялалтыг багаараа бүтээнэ.
- Бид өргөн мэдлэг, өөдрөг үзэл, бүтээлч хандлагыг эрхэмлэнэ.
- Бид зорилго, итгэл, урам зоригтойгоор ирээдүйг төлөвлөн бүтээнэ.

#### **Хариуцлага:**

- Бид ажилдаа эзэн байж, хариуцлагаа ухамсарладаг зарчимч байна.
- Бид хариуцлагатай байдлыг бусдын итгэлийг даах үндэс гэж үзнэ.
- Бид бүх нийтийн үйлчилгээний үүрэг хариуцлагаа эрхэмлэнэ.

#### **Брэнд нэр:**

- Бид “Монголын цахилгаан холбоо” хэмээх эрхэм алдрыг үргэлж дээдэлнэ.
- Бид компанийнхаа нэр төрийн илэрхийлэл гэдгээ үргэлж санана.
- Бид хэрэглэгч, харилцагч, хамтрагчиддаа компаниа үргэлж эерэгээр ойлгуулна.

### **УРИА ҮГ**

Холбоо хөгжлийн төлөө хамтдаа

### БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Монголын цахилгаан холбоо ХК нь 2021 оны ТУЗ-ийн 167 дугаар хурлаар бүтцийн өөрчлөлтийг дараах байдлаар шинэчлэн баталлаа.



Улаанбаатар хотын 4 бүсийн холбооны газар, Багануур, Налайх дүүргийн холбооны газар, 21 аймгийн холбооны газар, төв оффисийн 6 газар, 11 албаны бүтэцтэйгээр үйл ажиллагааг явуулж байна.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.



## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ




Интернэт	Суурин утас	Лавлах дуудлага үйлчилгээ	Телевиз	Хяналтын камерийн үйлчилгээ
<ul style="list-style-type: none"> <li>ADSL технологи</li> <li>Шилэн кабель, GPON технологи</li> <li>Түрээсийн шугам</li> <li>Бусад (IP хаяг, домайн нэр г.м)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>NGN технологи</li> <li>Холбох &amp; групп шугам</li> <li>IP Centrex</li> <li>1800xxxx, 1900xxxx тусгай дугаар</li> <li>Call center</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бүх төрлийн зар, мэдээ, мэдээлийн нэгдсэн лавлагаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>National TV кабелийн телевизийн үйлчилгээ</li> <li>TVROOM ОТТ үйлчилгээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Суурилуулалт</li> <li>Засвар үйлчилгээ</li> </ul>


### САЛБАРТ ЭЗЛЭХ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ




СУУРИН УТАС /мянган хэрэглэгчээр/




ИНТЕРНЭТ /мянган хэрэглэгчээр/



NATIONAL KATV /мянган хэрэглэгчээр/



"МЦХ" ХК-ийн зах зээлд эзлэх хувь



## ОНЦЛОХ АЖЛУУД



Шилэн кабелийн сүлжээг өргөтгөн, өндөр хурдны интернэт хэрэглэгч холбох хамрах хүрээг нэмэгдүүлсэн.



### АНДЦХБ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ

Японы KDDI сангийн буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн шилэн кабель суурилуулах төсөл хэрэгжүүлсэн.



Үйлчилгээний цар хүрээг тэлэн, технологийн компаниудтай харилцан ашигтай түншлэлд тулгуурлан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлсэн.



КаТВ үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлсэн.



Бизнесийн болон төрийн байгууллагуудад багц үйлчилгээг нэвтрүүлсэн.



### ХЭЛЭЛЦЭЭР

ТМ урсгалын өртгийг бууруулан, урсгалын нийт багтаамжийг нэмэгдүүлж, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулсан.



### ICT EXPO

Үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд зориулж шилэн кабель татаж, интернэтийн үйлчилгээг хүргэсэн.



Дан, хосолсон болон гуравласан багцыг үйлчилгээнд нэвтрүүлж, хэрэглэгчдийг үе шаттайгаар шилжүүлж байна.

## ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ

### FTTN сүлжээг байгуулах

21 аймгийн алслагдсан гэр хороололд 50 км шилэн кабелийн магистраль сүлжээг байгуулан хэрэглэгчдэд өндөр хурдны интернэт үйлчилгээг хүргэхэд бэлэн болсон.



Улаанбаатар хотод Гүнт, Санзай чиглэлийн алслагдсан гэр хорооллын айлуудыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажлын хүрээнд:

- 72 км шилэн кабель
- Хосолсон болон гуравласан багцын нийт 64 хэрэглэгч

### Японы KDDI сангийн шилэн кабель суурилуулах

Тэрэлж чиглэлийн шилэн кабелийн өргөтгөлийн ажлын хүрээнд:

- 53 км шилэн кабель
- Бодит хурдны интернэт - 29 хэрэглэгч
- Интернэтийн 168Mbps урсгалын гэрээ

### National КаТВ-ийн өргөтгөл

КаТВ үйлчилгээг Завхан аймгийн Тосонцэнгэл, Ховд аймгийн Булган суманд шинээр нэвтрүүлж үйлчилгээг хүргэсэн.



## ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцаа холбооноос бусад салбарууд уналтад орж зарим нэг нь бүрэн зогссон байдалтай гүн хямралд орсон бол бид үйл ажиллагаагаа хэвийн явуулж, түүнчлэн УОК-ын дэргэдэх Шуурхай штабд ажилласан ажилчдын болон бусад ажилчдын цалинг илүү цаг, шөнө цагийн нэмэгдэлтэй тогтмол олгон ажиллаж ирлээ.

## ОРЛОГЫН ТАСАЛДАЛ

- Төрийн байгууллагуудын зардлын төсвийг 50 хүртэл %-иар бууруулах шийдвэрийн дагуу үндсэн бизнес болох суурин утасны идэвхгүй хэрэглэгчийн тоо нэмэгдэж, хэрэглэгчийн гэрээний цуцлалт ихсэж орлого огцом 30% буурсан.
- Урт хугацаанд хатуу хөл хорио тогтоосны улмаас байгууллага болон хувь хэрэглэгчдэд биечилсэн борлуулалт хийх боломжгүй байсан нь TV Room хэрэглэгчийн төхөөрөмжийг худалдан борлуулан олохоор төлөвлөж байсан орлого 1 тэрбум төгрөгөөр тасрахад нөлөөлсөн.
- БНХАУ-д цар тахал гарсантай холбогдуулан хилийн боомтуудаа бүрэн хаасан тул хэрэглэгчийн болон сүлжээний тоног төхөөрөмжүүдийн худалдан авах үйл ажиллагаа саатаж хугацаандаа нийлүүлэгдэж чадаагүй зогсонги байдалд орсон нь орлого тасрах шалтгаан болсон.
- БШУЯ-тай хамтран ажиллах төлөвлөлтэй байсан боловч сонгон шалгаруулалтын нөхцөл шаалдлага өөрчлөгдсөн тул үйлчилгээний бүтэн багцыг авах боломжгүй болож 1,6 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөт орлого тасарсан

## ТӨЛӨВЛӨГДӨӨГҮЙ ЗАРДАЛ

- УОК-ын дэргэдэх Шуурхай штабд ажиллагсадад цалин, илүү цаг, шөнө цагийн нэмэгдэлтэй олгосон.
- Урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын багаж, хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний материал авсан
- Цар тахлын гамшгийн үед ажилчид бүтэн цагаар ажилласан тул халдварт өртөх эрсдэл өсөж ажилчдын төв салбарт 79,4%, ОН салбарт 61,1% хүртэл өвчилсөн. Өвдсөн ажилчдын ажил үүргийг орлон ажиллахад бусад ажилчдыг илүү цагаар ажиллуулж холбогдох цалингийн зардал өссөн.

## ЧИП ХОМСДОЛ

Томоохон төсөл хөтөлбөрүүдийн сонгон шалгаруулалт амжилттай болж нийлүүлэгчидтэй гэрээ байгуулсан боловч дэлхий дахинд тоног төхөөрөмжийн чипны хомсдол үүссэн тул үйлдвэрлэл үндсэндээ зогссон. Иймээс интернэт урсгалын хүчин чадал нэмэгдүүлэх, телевизийн тоног төхөөрөмж нийлүүлэлт хүлээгдэж байна.

## ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛ

Улс орны хэмжээнд эдийн засгийн царцанги байдал үүссэн, инфляц өсч худалдан авах барааны өртөг огцом өссөн нь тендер удаа дараа амжилтгүй болох гол шалтгаан болсон. Тоног төхөөрөмж, бараа материал бэлтгэн нийлүүлэх тендерт оролцогчид санал ирүүлэхгүй байгаагаас нийлүүлэлт, хэрэгжилт зогсонги байдалд ороод байна.

## КОВИД-19 ЦАР ТАХАЛ

Харилцаа холбооноос бусад салбарууд уналтад орж зарим нэг нь бүрэн зогссон байдалтай гүн хямралд орсон бол бид үйл ажиллагаагаа хэвийн явуулж, түүнчлэн УОК-ын дэргэдэх Шуурхай штабд ажилласан ажилчдын болон бусад ажилчдын цалинг илүү цаг, шөнө цагийн нэмэгдэлтэй тогтмол олгон ажиллаж ирлээ.

- Цар тахлын үед ажиллах 11 салбарт багтсан тул ажилчид бүтэн ажиллаж байсан тул халдварт өртөх эрсдэл төдий чинээ өсч нийт ажилчдын төв салбарт 79,4 хувь, орон нутгийн салбарт 61,1 хувь хүртэл өвчилсөн. Эдгээр ажилчдын хувьд гэрээсээ ажилласанд тооцон цалинг бүтэн олгосон ба өвдсөн ажилчдын ажил үүргийг орлон ажиллахад бусад ажилчдыг илүү цагаар ажиллуулах шаардлага гарч байсан.
- Коронавирус халдвар авсан 479 /69,52%/ ажилтан эрүүл мэндийн үзлэг үйлчилгээ авч, бүрэн эдгэрч ажилдаа орсон.

Цар тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд халдвар хамгааллын багаж, хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний материалд багагүй зардал гарсан.



## ДАРХЛААЖУУЛАЛТ

Компанийн нийт ажилтнууд вакцинжуулалтад

**1-р тунд 665 /96,51%/,  
2-тунд 660 /95,79%/,  
3-р тунд /28,01% / хамрагдсан.**

## УОК ШУУРХАЙ ШТАБД АЖИЛЛАСАН

УОК-ын дэргэдэх Шуурхай штабд манай ажилчдаас дайчлан ажиллуулах шийдвэр гарсны дагуу 24/7 хуваариар тасралтгүй ажиллаж цалинг илүү цаг, шөнө цагийн нэмэгдэлтэй олгосон.

- 3 машин
- 3 хүн

## ХАБЭА-Н СУРГАЛТ

Гамшгийн үед ажиллах албан хаагчид зориулж ХАБЭА болон галын аюулгүй байдлыг хангах сургалтыг сар болгон тогтмол давтамжтайгаар явуулсан.

## КОМПАНИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ



### “EMERGENCY CALL BOOTH”

Нийгмийн хариуцлагын хүрээнд бүх сүлжээнд 2 минут үнэгүй ярих боломжтой таксофоныг төв байрны гадна байрлуулж, 2021.11.04-ний өдрөөс үйлчилгээнд нэвтрүүлсэн.

11 сард өдөрт 10-20 дуудлага

12 сард өдөрт 30-40 дуудлага



### “ЦУСАА БЭЛЭГЛЭЭ”

Монголын цахилгаан холбоо ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд бид жил болгон цусаа хандивлаж хүндэт донорууд төрүүлсэн байгууллага болсон.



### “МОД ТАРИХ”

Монголын цахилгаан холбоо ХК-ийн ажилчид МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан ТЭРБУМ мод төслийн хүрээнд Улаанбаатар хот болон 21 аймагт мод тарив.



### “СУРГУУЛИЙН УТАС”

Дотоодын нөөц болоцоог ашиглан 10 ширхэг таксофоныг засаж үйлчилгээнд гаргах боломтой болсон бөгөөд нийслэлийн ЕБ-ын 1-р сургуульд байршуулсан.



## ЭМ ТИ СИ СЕРВИС ХХК

### Харилцаа холбооны үйлчилгээний аутсорсинг

Мобинет ХХК-тай холбооны болон шилэн кабелийн угсралт, суурилуулалт, цаашдын ашиглалт, үйлчилгээг хариуцан хийх гэрээг байгуулан 21 аймаг, 2 дүүрэгт нэвтрүүлээд байна.



### Камерын хяналтын цогц үйлчилгээ

Хяналтын камер суурилуулах, гадна, дотоод холбоог байгуулах, интернэтийн урсгал нийлүүлэх, цаашид ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах үйлчилгээг нэвтрүүлээд байна. 2021 оноос Барилгын хөгжлийн төвтэй хамтран орон нутаг дахь барилга, байгууламжийн хяналтыг хийх чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт 15 цэгт суурилуулах ажлыг эхлүүлээд байна.



### MTC Academy

МЦХ ХК болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудын инженер, техникийн ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшүүлэх, дадлагажуулах чиглэлээр 30 гаруй сургалт зохион байгуулсан.



### Тоон гарын үсэг

“Тридиум и-Секюрити” ХХК-тай хамтран АДХГ-аар тоон гарын үсгийг иргэд, аж ахуйн нэгжид олгох үйлчилгээг эхлүүлээд байна. Одоогийн байдлаар нийт 18 цэгт нэвтрэн, үйлчилгээг хүргэж эхэлсэн.



### UB Cab үйлчилгээг орон нутаг

16 аймгийн 18 цэгт UbCab, UbCab Express үйлчилгээг хүргэж эхлэхээр хамтран ажиллаж байна. 2021 оны байдлаар нийт 9 цэг үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.




### Huawei компанийн албан ёсны төлөөлөгч

Олон улсын байгууллагууд болон гадаад улсын үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын Huawei компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах албан ёсны түнш болсон.

## САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2021.12.31-ний хаалтын ханшаар 18,420,930,026 төгрөг байна. 2021 оны арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв.



### ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он	2020 он	2019 он	Өсөлт, бууралт	
				2021/2020	2020/2019
<b>Хувьцааны ханш / төгрөг /</b>					
Хаалтын ханш	712.05	347.54	405	105%	-14%
Хамгийн өндөр ханш	800	472	500	69%	-6%
Хамгийн бага ханш	379.92	307.29	381	24%	-19%
Дундаж ханш	609.09	392.15	428.88	55%	-9%
<b>Арилжаалагдсан тоо / ширхэг /</b>					
Хамгийн их /өдөрт /	20074	1850	5415	985%	-66%
Хамгийн бага /өдөрт /	1	1	1	0%	0%
Дундаж /өдөрт/	533	254	302	110%	-16%
Нийт	77320	16557	18157	367%	-9%
<b>Арилжааны үнийн дүн / төгрөг /</b>					
Хамгийн их /өдөрт /	12,044,601	741,850	2,382,600	1524%	-69%
Хамгийн бага /өдөрт /	649	402	405	61%	-1%
Дундаж /өдөрт/	320,928	96,905	128,588	231%	-25%
Нийт	46,534,525	6,298,820	7,715,268	639%	-18%
<b>ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/</b>	<b>18,420,930,026</b>	<b>8,990,955,721</b>	<b>10,477,461,780</b>	<b>105%</b>	<b>-14%</b>

## САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Санхүүгийн байдлын тайлан / аудитлагдсан /

MNT'000	2020	2021
Мөнгө,гүүнтэй адилтгах хөрөнгө	1,110,456	983,774
Авлага	2,084,623	2,748,282
Бусад санхүүгийн хөрөнгө	3,694,689	3,430,407
Бараа материал	2,726,488	2,701,204
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	514,748	1,703,704
Үндсэн хөрөнгө	22,285,402	22,204,401
Биет бус хөрөнгө	9,211,956	9,094,953
Бусад хөрөнгө	126,271	127,526
<b>Нийт хөрөнгө</b>	<b>41,754,634</b>	<b>42,994,251</b>
Богино хугацаат өр төлбөр	2,870,281	4,130,954
Урт хугацаат өр төлбөр	4,370,850	4,370,850
<b>Нийт өр төлбөр</b>	<b>7,241,131</b>	<b>8,501,804</b>
Эздийн өмч	2,587,028	2,587,028
Эздийн өмчийн бусад хэсэг	9,246,757	9,246,757
Хуримтлагдсан ашиг	22,679,719	22,658,663
<b>Нийт эздийн өмч</b>	<b>34,513,503</b>	<b>34,492,447</b>
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>41,754,634</b>	<b>42,994,251</b>

### Орлогын дэлгэрэнгүй тайлан / аудитлагдсан /

MNT'000	2020	2021
Борлуулалтын орлого /цэвэр/	19,246,768	17,990,130
Борлуулалтын өртөг	(14,340,981)	(13,523,395)
<b>Үйл ажиллагааны ашиг/(алдагдал)</b>	<b>4,905,787</b>	<b>4,466,735</b>
Борлуулалт, маркетингийн зардал	(1,443,132)	(1,256,557)
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,828,823)	(2,544,492)
Бусад зардал	(541,802)	(626,564)
<b>Нийт зардал</b>	<b>(4,813,757)</b>	<b>(4,427,613)</b>
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	92,030	39,122
Татварын зардал	(48,642)	(34,407)
<b>Цэвэр ашиг</b>	<b>43,389</b>	<b>4,715</b>

### 2021 ОНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



**ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ**

Үзүүлэлт / мянган төгрөг /	2020	2021
Төсвийн төлбөрт нийт дүн	3,508,477	3,303,800
а/Орлогын татварт	12,156	34,407
б/ НӨАТ	1,427,192	1,164,376
в/НДШ	1,599,707	1,661,550
г/Хүн амын орлогын татварт	398,701	409,518
д/Үл хөдлөхийн татварт	25,591	18,063
е/Гаалийн татварт	31,963	-
ж/Тээврийн хэрэгслийн татварт	4,273	4,736
и/Бусад татварт /Газрын төлбөр/	8,895	11,148

**2021 ОНД НОГДОЛ АШИГ ТАРААСАН ТАЙЛАН**

Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн №1 тоот тогтоолын дагуу компанийн 2020 оны цэвэр ашгаас ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж нэгж хувьцаанд 1 (нэг) төгрөг байхаар тогтоосон.

№	Хувьцаа эзэмшигчийн төрөл	Хувьцааны Тоо /ширхэг/	Ногдол ашгийн дүн /₮/	Татварын дараах шилжүүлсэн дүн ₮	Тараасан хэлбэр
1	Төрийн өмч	24,499,287	24,499,287.0	24,499,287.0	Төрийн сан дахь ТӨБЗГ-ын дансанд
2	Монгол улсын иргэн, хуулийн этгээд - нийт 3,896 хувьцаа эзэмшигч	1,265,351	1,265,351	1,138,815.90	ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хуваарилсан
3	Гадаадад амьдардаг иргэн, хуулийн этгээд - нийт 56 хувьцаа эзэмшигч	105,638	105,638	84,510.40	ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хуваарилсан
	Татварт суутгасан дүн	-	-	147,662.7	
	НИЙТ ДҮН	25,870,276 ширхэг	25,870,276 ₮	25,870,276 ₮	

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 11:00-14:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулагдлаа. 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөр тасалбар болгон бүртгэсэн 25,870,276.0 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3977 хувьцаа эзэмшигчдээс 24,500,642 ширхэг саналын эрх бүхий 11 хувьцаа эзэмшигч оролцож хурлын ирц 94.71 хувьтай байлаа.

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлууд

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай
4. 2019 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай
7. Охин компани байгуулах тухай

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүд

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын тайлан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов.  
Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Г.Эрдэнэбулган, Т.Лхагвасүрэн, Ж.Цогтбаяр, Ч.Цэвэгдорж, Ц.Шинэхүү, М.Лхагважав нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ц.Норовжамц, Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс тус тус сонгов.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
6. Охин компани үүсгэн байгуулах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын эзгүйд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэг (1/3) хараат бус гишүүн бөгөөд ердийн 6 гишүүн нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

### ТУЗ-ИЙН ДАРГА



**Т.Лхагвасүрэн**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн

### ЕРДИЙН ГИШҮҮД



**Г.Эрдэнэбулган**

ЗГ-ийн хэрэг эрхлэх газар, Хууль, эрхзүйн газар, Засгийн газрын референт



**Ж.Цогтбаяр**

СЯ, СХЭУГ-ын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга



**Ч.Цэвэгдорж**

ХНХЯ, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга



**Ц.Шинэхүү**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга



**М.Лхагважав**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

### ХАРААТ БУС ГИШҮҮД



**Ж.Тамир**

Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга



**Ю.Бат-Эрдэнэ**

Завхан баялаг ХХК Гүйцэтгэх заирал



**Ц.Норовжамц**

Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор

Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо, Цалин, урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодтой үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон холбоотой Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг шинэчлэн байгууллаа. Хороод нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

<b>Аудитын хороо</b>	<b>Нэр дэвшүүлэх хороо</b>	<b>Цалин урамшууллын хороо</b>
Дарга	Дарга	Дарга
Ц.Норовжамц	Т.Лхагвасүрэн	Ж.Тамир
Гишүүн	Гишүүн	Гишүүн
Ж.Цогтбаяр,	Ж.Тамир	М.Лхагважав
Ю.Бат-Эрдэнэ	Ц.Норовжамц	Ю.Бат-Эрдэнэ

### **Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа**

Төлөөлөн удирдах зөвлөл нь жил бүр хэлэлцэх асуудлаар ерөнхий төлөвлөгөө боловсруулан ажиллаж хэвшсэн бөгөөд 2021 онд 7 удаагийн хурлаар, 16 асуудал хэлэлцэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9 хурал, 20 асуудал хэлэлцэж шийдвэрлэлээ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нийт 15 тогтоол, 4 тэмдэглэл гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан биечилсэн байдлаар 3, цахимаар 4, биечилсэн болон цахим хосолсон 2 удаа тус тус хуралдлаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын хувьд Цалин, урамшууллын хороо нэг удаа, Аудитын хороо хоёр удаа, Нэр дэвшүүлэх хороо хоёр удаа тус тус хуралдаж санал, дүгнэлтээ боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан байна. Аудитын хороо 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцууллаа.





# Call Center

дуудлага бүрийг холбоно



"МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО" ХК

ТАНАЙ  
БАЙГУУЛЛАГЫН  
ХЭРЭГЛЭГЧ,  
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН  
ДУУДЛАГА БҮРИЙГ  
ХОЛБОНО.

#Call center  
#дуудлага бүрийг холбоно

 [www.telecommongolia.mn](http://www.telecommongolia.mn)

 Telecom Mongolia

 7000 8000